



**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН НУТАГТ ОРШИХ
“МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК-ИЙН “ХӨӨТИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ”-Н 2023
ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-012199/
/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2095025/

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын мэргэжилтэн

/...../

Биелэлтийг тайлагнасан:

“Монголын Алт” (МАК) ХХК-ний
Үйлдвэр Техникийн Газрын захирал



/Д. Баярсайхан/ – з

Байгаль орчны инженер

/Б.Гэрэлтуяа/

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	3
3. УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
4. ХӨӨТИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН	9
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	10
6. НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	18
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	19
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	20
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	26
12. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТЫН БИЕЛЭЛТ.....	30
13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	30
14. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ...	37
15. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	41
16. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРСАН НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ	41
17. ДҮГНЭЛТ	42
18. ХАВСРАЛТУУД	43

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Компанийн танилцуулга:

“Монголын Алт” (МАК) ХХК нь 1993 онд үүсгэн байгуулагдсан, үндэсний хөрөнгө оруулалттай, Монгол улсын тэргүүлэх компаниудын нэг билээ. Манай компани уул уурхай, барилгын материал төсөл, хөдөө аж ахуй, агаарын тээвэр, үл хөдлөх хөрөнгө, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагааныхаа туршид улс, орон нутгийн төсөвт татвар төлөлтөөрөө тогтмол тэргүүлж ирсэн бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, дэлхийд тэргүүлэх сүүлийн үеийн дэвшилтэт техник технологийг үйл ажиллагаа, үйлдвэрлэлдээ нэвтрүүлж, улс эх орныхоо хөгжил, эдийн засагт даацтай хувь нэмэр оруулах томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. “Монголын Алт” (МАК) ХХК-ийн Хөх цав цемент-шохойн үйлдвэрийн төсөл болон дагалдах уурхайнуудын үйл ажиллагааг хариуцан хэрэгжүүлэхээр 2014 онд “МАК ЦЕМЕНТ” ХХК байгуулагдсан бөгөөд Хөөтийн уурхайн үйл ажиллагааг хариуцдаг билээ.

Компанийн байгаль орчны бодлого:

Бидний эрхэм зорилго: Компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд байгаль орчинд үүсч болох аливаа сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах талаар анхааран ажиллах, байгалийн нөөцийг удаан хугацаанд тогтвортой ашиглах нь компанийн нэн тэргүүний зорилго юм.

Бидний дээдлэх үнэт зүйлс: Компани ба түүний салбар нэгжүүд нь үйлдвэр, уурхайн төслийг боловсруулах шатнаас үйл ажиллагааныхаа бүх хүрээнд байгаль орчны асуудлыг байнга анхаарч Монгол улс болон олон улсын хэмжээнд мөрдөж буй уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны холбогдолтой хууль, журам, гэрээ хэлэлцээрийг дагаж мөрдөнө. Эх орон, төрсөн нутаг, усаа хайрлан хамгаалах нь компанийн бүх ажилчид албан хаагчдын үнэт зүйл болох учиртай.

Баримтлах бодлого: Манай компани нь дараах зорилтуудыг дэвшүүлж ажилладаг.

Үүнд:

- Байгалийн нөөц баялгийг урт удаан хугацаанд тогтвортой, үр ашигтай зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар баримталж ирсэн төрийн бодлогыг хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны стандарт, хэм хэмжээ, дүрэм журмыг чанд сахин биелүүлж, дотоодын болон хөндлөнгийн байгаль орчны хяналтыг тогтмол гүйцэтгэх;

- Улсын болон орон нутгийн хэмжээнд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байгаль орчныг хамгаалах чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах;

- Олон улсын байгаль орчны байгууллагууд болон байгаль орчинд ээлтэй

дэвшилтэт технологи бүхий туршлагатай компаниудтай хамтран ажиллаж, улмаар олон улсын байгаль орчны стандартуудыг өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

- Үл нөхөн сэргээгдэх байгалийн нөөц баялгийг ариг гамтай, хаягдалгүй технологи болон дахин боловсруулах аргаар ашиглах;

- Байгалийн нөөцийн ашиглалтын үр ашгийг өндөр түвшинд байлгах зорилгоор тогтмол судалгаа шинжилгээг явуулж орчин үеийн үр ашигтай техник, технологийг үйлдвэрлэлдээ тууштай нэвтрүүлэх;

- Үйлдвэрлэл, уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэдийн соёл, өв уламжлалыг хүндэтгэн хамгаалах, тэдний биет өв, ёс заншлын талаархи мэдээлэл, тэдгээрийн ач холбогдлыг компанийн ажилчдад тогтмол таниулах;

- Өөрийн компанийн байгаль орчны талаар баримтлах бодлого зарчмыг хамтран ажиллаж буй түнш, гэрээт гүйцэтгэгч нарт зааж таниулах, тавих шаардлагыг өндөржүүлэх замаар байгаль орчны чиглэлээр тэдний хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх зэрэг болно.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАЗРЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ордын ерөнхий мэдээлэл, байршил:

Хөөтийн нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт Говь Угтаал- Баянжаргалангийн өндөрлөгийн төв хэсэгт тогтсон Хөөтийн хотгорт оршино. Ордын тусгай зөвшөөрлийн MV-12199, MV-020297 талбайнуудын газарзүйн солбилцол:


Хүснэгт 1: Ордын газарзүйн солбилцлүүд

№	Уртраг	Өргөрөг	№	Уртраг	Өргөрөг
1	107° 40' 00"	45° 41' 30"	3	107° 44' 00"	45° 40' 00"
2	107° 44' 00"	45° 41' 30"	4	107° 40' 00"	45° 40' 00"

Хөөтийн нүүрсний орд ба хот суурин газрууд, бусад объектуудын байршил:

Хүснэгт 2: Бусад байршил хоорондын зай

№	Хот, суурин газрын нэр	Ордын байршил	
		Зүг	Зай [км]
1	Улаанбаатар хот	Зүүн урагш	300
2	Чойр	Баруун урагш	100
3	Мандалговь	Зүүн хойш	130
4	Баянжаргалан сум Арагтай	Баруун тийш	26



Зураг 1: Хөөтийн нүүрсний ордын байр зүйн зураг

Дэд бүтэц: Хөөтийн нүүрсний орд нь Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 300 км, төмөр замын зангилаа бүхий Чойр хотоос баруун урагш 100 км, аймгийн төв Мандалговь сумаас зүүн хойш 130 км, Баянжаргалан сумын төв Арагтайгаас баруун тийш 26 км зайд Хөөтийн хотгорт оршино.

Зам тээврийн нөхцөл: Орд нь бүтэн жилийн турш бусад хот сууринтай зам тээврээр холбогдох боломжтой бөгөөд Улаанбаатар хотоос төмөр замын Чойр өртөө болон Говь-Сүмбэр аймгийн төв хүртэл асфальтан замаар, цааш Говь-Сүмбэр аймгийн төвөөс орд хүртэл шороон замаар холбогдоно.

Уурхайн жилийн хүчин чадал: Техник эдийн засгийн үндэслэлийн дагуу ашиглалтыг явуулж 2023 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр 1160 метрийн түвшин хүртэл гүнзгийрч нийт 2 сая.м³ хөрс хуулж, 406 мян.тн нүүрс олборлох зорилттой ажиллаж байна. Уурхайн ажиллах горим: 2023 онд Хөөтийн уурхайн ажиллах горим дараах байдлаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт 3: Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ	Тайлбар
1	Жилийн ажлын горим	Тасралтгүй		
2	Жилийн календарьт хугацаа	хоног	36	
3	Жилд ногдох ажлын бус хоног	хоног	30	Баяр ёслол
4	Цаг агаарын саатал хүндрэл	хоног	5	
5	Жилд ажиллах хоног	хоног	30	
6	Хоногийн ажлын горим	ээлж	2	
7	Ээлжийн хугацаа	цаг	12	

Ажиллах хүчний мэдээлэл: Уурхай нь 2023 оны бүтэц орон тоогоор 235 хүний бүрэлдэхүүнтэй батлагдсан. Одоогийн байдлаар нэг ээлжинд 30-35 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагааг явуулж байна.

Уурхайн нүүрс олборлолт болон тээвэрлэлт: 2023 оны 10-р сарын 01-ны өдрийн байдлаар Хөөтийн уурхайн өөрийн үйлдвэрүүд болон уурхайн ам нөхцөлөөр нийт 149 мян.тн нүүрсийг худалдан борлуулсан байна. Нүүрс олборлолт, борлуулалтын ажилд Hyundai-850, CAT-395 зэрэг экскаваторууд ажилласан. Өөрсдийн үйлдвэрийн нүүрс тээвэрлэлтийг гадны гэрээт компаниар гүйцэтгүүлж байна.

Уурхайд ашиглагдаж буй техник тоног төхөөрөмж: 2023 онд уурхайн ажилд хэрэглэгдэж буй тоног төхөөрөмжүүдийг хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт 4: Уурхайд ажиллаж буй техникуудийн жагсаалт

Техникийн нэр	Марк	Хүчин чадал	Тоо ширхэг	Зориулалт
Экскаватор	CAT-395	6 м3	1	Нүүрс, хөрс олборлолт
Экскаватор	HYUNDAI-850	5 м3	1	Нүүрс, хөрс олборлолт
Автосамосвал	Белаз-75131	110 тн	2	хөрс, нүүрс зөөх
Автосамосвал	Хово-371	50 тн	2	хөрс, нүүрс зөөх
Бульдозер	CAT-D9R	18.5 м3	1	Шимт хөрс хуулах, овоолго нээж, ул тааз түрэх
Усны белаз	Белаз-76473	32 тн	1	Зам усалгаа хийх
Автогрейдер	CAT-160K		1	Зам талбай тэгшилж янзлах
Дугуйт ачигч	CAT-986	6.7 м3	1	Нүүрс ачилт хийх, хөмсөг далан тавих

Дээрх уулын ажлын зориулалттай техникуудээс гадна түлшний тэрэг, галын машин болон дотоод үйлчилгээний зориулалттай автомашинууд уурхайн хэрэгцээнд ашиглагдаж байна.

Уурхайн барилга байгууламж: Төслийн талбайд дараах барилга байгууламжууд байна:

- Ажилчдын түр хотхон / амрах байр
- Оффис, сургалтын өрөө
- Зоогийн газар
- Халуун ус, хувцас угаалгын байр
- Хөөт 35кВ дэд станц
- Засвар үйлчилгээний хэсэг-хаягдал тосыг түр хадгалах цэг
- Сэлбэг хэрэгслийн агуулах
- Насосчны байр
- Авто-пүү
- Зөөврийн шатахуун түгээгүүр
- Хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах цэг


Уурхайн цахилгаан хангамж: Шивээ-Говь 35кВ ЦДАШ нь Хөөтийн уурхайгаас 26км зайд байрлах Баянжаргалан сумын 35/15/10кВ дэд станцыг тэжээнэ. Үүнээс Хөөтийн уурхайн 35/6 дэд станц нь 3 гаралттай тэжээгдэж уурхайн засвар үйлчилгээний төв, ажилчдын хотхон болон зэрэгцээ үйл ажиллагаа явуулдаг Биг Могоул уурхайг тус тус цахилгаан эрчим хүчээр хангаж байна.



Зураг 2: Хөөтийн уурхайн цахилгаан дамжуулах 35кВ дэд станц

Унд ахуйн ус: Хөөтийн хотгорын хэмжээнд хийсэн хайгуулын өрөмдлөгийн цооногт гүний ус илэрдэг боловч эрдэсжилт ихтэй тул ундны болон техникийн хэрэгцээнд ашиглахад тохиромжгүй. Иймээс уурхайгаас 26км зайд байрлах Баянжаргалан сумын худгаас унд ахуйн усыг зөврөөр хангаж байна.

График 1. Унд, ахуйн усны хэрэглээ



Шүүрлийн ус: 4 дүгээр сараас эхлэн сумын Байгаль орчны мэргэжилтний орлогчийг байлцуулан уурхайгаас ус шавхан зайлуулах хэсэгт байршуулсан насост тоолуур суурилуулан шүүрлийн ус шавхан зайлуулах ажлыг эхлүүлсэн. Бид усны тухай хуулийн 30.1.4 дэх заалтын дагуу уурхайн шүүрлийн усыг шавхан зайлуулах хэсэгт Стандарт

хэмжилзүйн газраар баталгаажуулсан тоолуур суурьлуулсан бөгөөд сар бүр сумын Байгаль орчны мэргэжилтнээр /орлогч/ уурхайгаас шавхан зайлуулсан шүүрлийн усны хэмжээ, тоолуурын заалтыг хянуулан акт үйлдэж байна.

Доорх графикаас тайлант оны IV сараас IX сарын турш шавхан зайлуулсан шүүрлийн усны хэмжээ болон шүүрлийн ус ашиглалтын хэмжээг харна уу.

График 2. Шүүрлийн ус шавхан зайлуулсан хэмжээ ба түүний ашиглалт





График 3. Шүүрлийн ус шавхан зайлуулсан хэмжээ ба нийт ашигласан усны хэмжээ



Ил зумфны гүн нь 1.5м, өргөн нь 2.5м-ээс Д-315 усны насосаар соруулж 32тн-ы Белазаар 16м өргөнтэй, 1.0-2.5км урт ил уурхайн доторх зам болон уурхайгаас овоолго хүрэх зам талбайг өдөрт 1-2 рейсээр 7 хоногт 3-7 удаагийн давтамжтайгаар усалж тоосжилтыг дарсан. Тайлант оны IV-IX сарын хооронд нийт 95361м³ ус шавхан зайлуулсан бөгөөд үүнээс 4784м³ усыг зам усалгаанд, 1072м³ усыг ногоон байгууламж услахад зарцуулсан нь нийт шавхан зайлуулсан усны 6%-ийг /5856м³/ эзэлж байна.

3. УУРХАЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Агаарын чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Уурхайн үйл ажиллагаанаас агаар мандалд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь тоосжилт, хорт хий, угаа, нүүрсний тоосонцор байж болох юм. Уурхайн байрлаж буй хэсэг нь хуурай уур амьсгалтай, салхи шуурга ихтэй, говь цөлийн бүс бөгөөд ургамлан бүрхэвч тачир сийрэг, нимгэн давхаргатай хөрс тул тоосжилт ихээр үүсэх боломжтой юм. Хөрс хуулалт, хөрсний догол, мөргөцөг гаргах, мөн олборлолт хийх зэрэг ажлууд хийх явцад агаарт үүсэх их хэмжээний тоос, салхи, шуургаар дамжин тархалт ихэснэ. Говийн нөхцөлд салхины хурдны давтагдал их байдаг нь ордын үйл ажиллагааны нөлөөгөөр газрын хөрснөөс суларсан шороо хийсч агаар бохирдуулах нь ихсэж болзошгүй юм.

Хөрсний чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хөөтийн уурхай орчмын хөрс нь шим тэжээлийн түвшингээр тааруу, ялзмагийн агууламж бага 0.24-2.96 %, элсэнцэр, элсэрхэг хөнгөн механик бүрэлдэхүүнтэй учир элэгдэл эвдрэлд орохдоо амархан хөрс юм. Уулын малталт, олборлолтын ажлын талбайг бэлтгэх, зам шинээр гаргах зэрэг хөрсний өнгөн хуулалт хийх, газар шорооны ажлыг эхлүүлэх үйл ажиллагаатай холбоотойгоор хөрс эвдэрч элэгдэлд орно. Уурхайд ашиглагдаж байгаа хүнд машин механизмын хөдөлгөөн, түрэлтээр орчны хөрсний үе давхаргууд гэмтэж, бороо хур ихтэй үед хөрсөн дээр хонхор үүсч хөрс эвдрэх магадлалтай.

Усны чанарт нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Усны эх үүсвэр болох худгийн ойр орчимд гүний усыг бохирдуулах үйл ажиллагаа явуулах, урсгалын эхэнд ус бохирдуулах үйл ажиллагаа явуулах (машин угаах, үйлдвэрийн болон ахуйн хог хаягдал хаях), шатах тослох материал хөрсөнд асгарах зэрэг нь хөрсний сул ус болон хур тунадсаар дамжиж ундны ус цаашлаад гүний усыг бохирдуулж болзошгүй.

Амьтан, ургамлын зүйлийн бүрдэлд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Хөрс хуулалт болон тэсэлгээ, нүүрс тээврийн үйл ажиллагаатай холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэлд орж ургамлан нөмрөг, тэжээллэг ашигт ургамлын зүйл буурах аажмаар алга болох эрсдэлтэй. Нүүрс олборлолт, тээврийн үед их хэмжээгээр тоосонцор агаарт дэгдэх үед нарны цацрагийн шууд тусгалыг хаах түүний нөлөөгөөр ургамлын ургалт багасч анхдагч бүтээгдэхүүний бүтээмж буурах магадлалтай. Буурсан тохиолдолд идэш тэжээлийн гинжин хэлхээнд өөрчлөлт орох, амьтад идэш тэжээлээ даган нүүдэллэх тухайн нутгаас даажих, хэрвээ идэш тэжээлээр дамжин хүнд металл

болон химийн хорт нэгдлүүд амьтны биед орсон тохиолдолд тэдгээрийн генийн санд өөрчлөлт орох гэх мэт эрсдэл гарч болзошгүй юм.

4. ХӨӨТИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН

Дундговь аймгийн Баянжаргалан суманд орших Хөөтийн нүүрсний ил уурхайн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлав. Түүний дагуу тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийг нэг бүрчлэн тодорхойлж, хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно.

2023 оны Хөөтийн уурхайн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаанууд, түүний үр дүнг дурдвал:

- “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг дэмжих, мөн уурхайн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй ургамлан нөмрөгийн талхалалт болон тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн хотхоны гадна болон дотоод талбайд 6 төрлийн нийт 1044 ширхэг мод тарьсан.

- Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Баянжаргалан сумын нутаг дэвсгарт 225 ширхэг улиас мод тарьж ургуулан, гүний худгийн засварлан ажиллагаанд оруулж өдөр тутмын арчилгаа усалгааг хийсэн.

- Хөөтийн уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй гол ба болзошгүй сөрөг нөлөөллийг хянах, бууруулах зорилгоор агаарын чанар, газрын доорх ус, хөрсөн бүрхэвч зэрэг чиглэлээр орчны хяналт шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэнд нэгтгэн илэрхийлэв.

Хүснэгт 5. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилт

д/д	Байгаль орчны хамгаалах арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн ажлын тоо	Гүйцэтгэсэн ажлын тоо	Хийгдэж буй болон хойшлогдсон ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	12	12	-
2	Нөхөн сэргээлт, Тэрбум модны үндэсний хөдөлгөөн	3	3	-
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	1	1	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	1	1	-

5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	Ажил төлөвлөөгүй.	Ажил төлөвлөөгүй.	-
6	Осол эрсдэлийн менежмент	9	9	-
7	Хог хаягдлын менежмент	5	5	-
8	Байгаль орчны төлөвлөгөөт аудит	1	1	-
9	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	10	10	-
10	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	11	11	-
11	Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа	3	3	-
	Нийт	56	56	-

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
1	Ус шүршигч төхөөрөмжийн судалгаа хийх, тоосжилтын эх үүсвэрийг чийгшүүлэх	Төслийн талбай	Ус шүршигч төхөөрөмжийн судалгааг цахим сайтууд ашиглан хийсэн ба уурхайн дотоод зам талбайн усалгааг усны белазаар тогтмол хийж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
2	Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилтыг дарах, хөрсийг бэхжүүлэх зориулалт бүхий замын тоос дарагч бодисын судалгааг хийх, тоосжилтын эх үүсвэрийг чийгшүүлэх	Төслийн талбай	Хөрс бэхжүүлэх, тоос дарагч бодисын судалгааг цахим сайт ашиглан хийсэн ба уурхайн дотоод зам талбайн усалгааг усны белазаар тогтмол хийж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
Усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
3	Уурхайн шүүрлийн усыг ус шавхах хэмжээг хамгийн их байхаар сонгож ажиллах ба шавхсан усыг шавхан зайлуулах бөгөөд усыг автозамын усалгаанд ашиглах	Төслийн талбайд	Шүүрлийн усыг өдөр бүр 4-5 цагийн турш шавхан зайлуулдаг ба усыг зам, ногоон байгууламжийн усалгаанд ашиглаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт

4	Уурхайн дэвсгэр талбай дахь ШТС, засварын газар зэрэг шатах тослох материал алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд болон уурхайн хүнд машин техник, тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, шаардлагатай багаж хэрэгслээр тоноглох	Төслийн талбайд	Өдөр бүр ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, техникийн бүрэн бүтэн байдлыг шалгадаг ба засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаанаас шатах тослох материал хөрсөнд асгарсан тохиолдолд тэр даруй цэвэрлэх, саармагжуулах арга хэмжээ авч, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, саармагжуулах бодисыг бэлэн байлгадаг.	950,000.0	Тухай бүрт
5	Шатах, тослох материалыг стандартын шаардлага хангасан, зориулалтын сав, агуулахад хадгалах, алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж төлөвлөсөн төлөвлөгөө боловсруулж ажиллах	Төслийн талбайд	Шатах, тослох материалыг зориулалтын бэлтгэсэн талбайд хадгалан, бүртгэл хөтөлдөг ба уурхайн хэмжээнд мөрдөх асгаралтын журам, төлөвлөгөөг уурхайн даргаар батлуулсан.	Үйл ажиллагааны зардлаас	3-р улиралд
Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр					
6	ЗҮТ-с гарах хаягдал тосны хадгалалтанд хяналт тавьж шатах тослох материал алдагдаж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, машин техникийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгаж хөдөлгөөнд оролцуулах, шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд хөрсийг хуулан бохирдсон хөрсний овоолгод хүргэн саармагжуулах.	Уурхайн талбай	Өдөр бүр ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, техникийн бүрэн бүтэн байдлыг шалгадаг ба засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаанаас шатах тослох материал хөрсөнд асгарсан тохиолдолд тэр даруй саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авч ажилладаг.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
7	Уурхайн замын урсгал засваруудыг цаг тухайд нь хийх ба замгүй газраар буюу хөрсөн дээгүүр тээврийн хэрэгслүүд зорчих шаардлагатай болсон нөхцөлд зам засварын ажил дууссаны дараагаар шинээр зам	Уурхайн талбай	Уурхайн дотоод зам талбай болон нүүрс тээврийн замыг тогтмол хусаж сайжруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт

	гаргасан газрыг нөхөн сэргээж байгалийн унаган төрхөд нь ойртуулах				
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах чиглэлээр					
8	Ил уурхайг олборлох явцад хуулсан шимт хөрсийг стандартын дагуу хадгалж, овоолго үүсгэн салхинд хийсэх, усанд автах, хаягдал чулуулгийн овоолго болон бусад материалаар бохирдохоос хамгаалах	Шимт хөрсний овоолго	Монгол Улсын стандарт MNS 5916:2008 газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалтын дагуу шимт хөрсний овоолгыг үүсгэсэн. Уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахаас өмнө хөрсний үе давхаргын зузааныг тодорхойлж, харилцан адилгүй тогтоосон гүн хүртэл шимт хөрсийг хуулж хадгалж, чанарын хяналт хийж гүйцэтгэв.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
9	Засвар үйлчилгээний үед гарсан аюултай хог хаягдал асгарч хөрсөн бүрхэвчийг бохирдуулсан тохиолдолд богино хугацаанд хөрсөн бүрхэвчийг хуулж бохирдсон хөрсний овоолгод байршуулж саармагжуулах, шаардлагатай багаж хэрэгслээр тоноглон байх.	Үйлчилгээний талбайд	Засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаанаас гарсан аюултай хог хаягдыг зориулалтын бэлтгэсэн талбайд хадгалан бүртгэл хөтөлдөг. Мөн хөрсөнд асгарсан тохиолдолд тэр даруй хусаж цэвэрлэн, бэлтгэсэн цементэн талбайд саармагжуулах арга хэмжээ авч ажилладаг.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр
Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг буруулах чиглэлээр					
10	Уурхай орчмын барилга байгууламжуудыг тойруулан хашсан торон хашааны бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах ба нурж эвдэрсэн тохиолдолд засаж мал, амьтан нэвтрэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх.	Уурхайн талбайд	Барилга байгууламжийг тойруулан хашсан хашааны бүрэн бүтэн байдал, уурхайн талбай, ногоон байгууламжид мал орохоос сэргийлж уулын мастер, аж ахуйн ажилтнууд байнгын хяналт тавьж ажилладаг.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүрт
11	Цаг агаар хүндэрч бэлчээр нутгийн ан амьтан идэш тэжээлээр дутмаг үед мал амьтдад өвс, тэжээл тавьж өгөх зэргээр зориудын тэтгэх (биотехникийн) арга хэмжээ авах	Уурхайн талбайд	Ан амьтан хамгаалах, идэш тэжээлээр хангах зорилгоор Баянжаргалан сумын ЗДТГазарт 200 боодол өвс хүлээлгэн өгсөн.	2,305,157.0	Жилдээ

12	Уурхайн талбай орчимд харагдсан амьтадын бүртгэлийг уурхайн ажилчдын оролцоотойгоор бүртгэн амьтдын тархалт, байршлын талаар мэдээллийг цуглуулах	Уурхайн орчимд	Уурхайн талбайн орчимд үзэгдсэн амьтдын бүртгэлийг хийж сар бүр ERP системд оруулан мэдээллийн сан үүсгэсэн.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
Нийт зардал, мян.төг				3,255,157.0	

5.1 Ус шүршигч төхөөрөмжийн судалгаа хийх, тоосжилтын эх үүсвэрийг чийгшүүлэх

Тоосжилт дарах ус шүршигч төхөөрөмжийн судалгааг олон улсын туршлага, цахим сайтууд ашиглан хийж гүйцэтгэсэн ба уурхайн тоосжилтыг дарахаар 32тн усны белазаар өдөрт 1-2 удаагийн давтамжтай усалгааг хийж 4784м³ ус ашигласан.

5.2 Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй тоосжилтыг дарах, хөрсийг бэхжүүлэх зориулалт бүхий замын тоос дарагч бодисын судалгааг хийх, тоосжилтын эх үүсвэрийг чийгшүүлэх

Хөрс бэхжүүлэх бодисын судалгааг олон улсын туршлага, цахим сайтууд ашиглан хийж гүйцэтгэсэн ба уурхайн тоосжилтыг дарахаар 32тн усны белазаар өдөрт 1-2 удаагийн давтамжтай усалгааг хийж 4784м³ ус ашигласан.

/Ус шүршигч төхөөрөмж, хөрс бэхжүүлэгч бодисын судалгааг [ЭНД](#) дарж үзнэ үү/



Зураг 3. Уурхайн технологийн замыг усны Белаз усалж замын тоосыг дарж байгаа нь.

5.3 Уурхайн шүүрлийн усыг ус шавхах хэмжээг хамгийн их байхаар сонгож ажиллах ба шавхсан усыг шавхан зайлуулах бөгөөд усыг автозамын усалгаанд ашиглах

2023 оны 03 дугаар сарын 31-ний өдөр шүүрлийн усны 250м³ цагийн хэмжих хязгаартай 150мм голчтой тоолуурыг Баянжаргалан сумын Байгаль орчны мэргэжилтний орлогчийг байлцуулан суурьлуулж шүүрлийн усыг шавхан зайлуулах ажил эхэлсэн.

Шүүрлийн усыг өдөр бүр 4-5 цагийн турш шавхан зайлуулдаг ба усыг зам, талбай, ногоон байгууламжийн усалгаанд ашигладаг.



Зураг 4. Шүүрлийн усны насос тоолуур суурьлуулж байгаа нь

5.4 Уурхайн дэвсгэр талбай дахь ШТС, засварын газар зэрэг шатах тослох материал алдагдаж болзошгүй эх үүсвэрүүд болон уурхайн хүнд машин техник, тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгах, шатах тослох материал алдагдсан тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, шаардлагатай багаж хэрэгслээр тоноглох


Өдөр бүр ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, техникийн бүрэн бүтэн байдлыг шалгадаг ба засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаанаас шатах тослох материал хөрсөнд асгарсан тохиолдолд тэр даруй цэвэрлэх, саармагжуулах арга хэмжээ авч, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, саармагжуулах бодисыг бэлэн байлгадаг.



Зураг 5. Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон бохирдсон хөрс саармагжуулах бодис

5.5 Шатах, тослох материалыг стандартын шаардлага хангасан, зориулалтын сав, агуулахад хадгалах, алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж төлөвлөсөн төлөвлөгөө боловсруулж ажиллах

Шатах, тослох материалыг зориулалтын бэлтгэсэн талбайд хадгалж, бүртгэл хөтөлдөг ба уурхайн хэмжээнд мөрдөх асгаралтын журам, төлөвлөгөөг уурхайн даргаар батлуулсан.

№	Нэр тэмдэгт	Хэмжээ	2023 онд бүртгэл												Нийт	
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12		
1	Шатах тос, дизель тос, керосин	литр														
2	Шатах тос, дизель тос, керосин	литр														
3	Шатах тос, дизель тос, керосин	литр														
4	Шатах тос, дизель тос, керосин	литр														
5	Шатах тос, дизель тос, керосин	литр														
6	Шатах тос, дизель тос, керосин	литр														
7	Шатах тос, дизель тос, керосин	литр														
8	Шатах тос, дизель тос, керосин	литр														
9	Шатах тос, дизель тос, керосин	литр														
10	Шатах тос, дизель тос, керосин	литр														
11	Шатах тос, дизель тос, керосин	литр														
12	Шатах тос, дизель тос, керосин	литр														
13	Шатах тос, дизель тос, керосин	литр														
14	Шатах тос, дизель тос, керосин	литр														
15	Шатах тос, дизель тос, керосин	литр														
16	Шатах тос, дизель тос, керосин	литр														
17	Шатах тос, дизель тос, керосин	литр														
18	Шатах тос, дизель тос, керосин	литр														
19	Шатах тос, дизель тос, керосин	литр														
20	Шатах тос, дизель тос, керосин	литр														

Зураг 6. АХХ хадгалах талбай болон бүртгэлийн хуудас

5.6 ЗҮТ-с гарах хаягдал тосны хадгалалтанд хяналт тавьж шатах тослох материал алдагдаж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, машин техникийн бүрэн бүтэн байдлыг өдөр бүр шалгаж хөдөлгөөнд оролцуулах, шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд хөрсийг хуулан бохирдсон хөрсний овоолгод хүргэн саармагжуулах

Өдөр бүр ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, техникийн бүрэн бүтэн байдлыг шалгадаг. Тайлант онд засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаанаас 3 удаагийн асгаралт үүссэн ба бохирдсон хөрсийг тэр даруй хуулж авч цэвэрлэн, саармагжуулах арга хэмжээ авч ажилласан.



Зураг 7. Хөрсөнд асгарсан шатах тослох материалыг цэвэрлэж байгаа нь

5.7 Уурхайн замын урсгал засваруудыг цаг тухайд нь хийх ба замгүй газраар буюу хөрсөн дээгүүр тээврийн хэрэгслүүд зорчих шаардлагатай болсон нөхцөлд зам

засварын ажил дууссаны дараагаар шинээр зам гаргасан газрыг нөхөн сэргээж байгалийн унаган төрхөд нь ойртуулах


Уурхайн дотоод зам талбай болон уурхайгаас могойн гол хүртэлх 39 км нүүрс тээврийн замыг хусаж сайжруулдаг ба олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлж замын хажуугаар шуудуу далан үүсгэсэн.



Зураг 8. Нүүрс тээврийн зам хусаж сайжруулж байгаа нь

5.8 Ил уурхайг олборлох явцад хуулсан шимт хөрсийг стандартын дагуу хадгалж, овоолго үүсгэн салхинд хийсэх, усанд автах, хаягдал чулуулгийн овоолго болон бусад материалаар бохирдохоос хамгаалах

Монгол Улсын стандарт MNS 5916:2008 газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалтын дагуу шимт хөрсний овоолгыг үүсгэсэн. Уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахаас өмнө хөрсний үе давхаргын зузааныг тодорхойлж, харилцан адилгүй тогтоосон гүн хүртэл шимт хөрсийг хуулж хадгалж, чанарын хяналт хийж гүйцэтгэв.



Зураг 9. Шимт хөрсний овоолго үүсгэсэн байдал

5.9 Засвар үйлчилгээний үед гарсан аюултай хог хаягдал асгарч хөрсөн бүрхэвчийг бохирдуулсан тохиолдолд богино хугацаанд хөрсөн бүрхэвчийг хуулж бохирдсон хөрсний овоолгод байршуулж саармагжуулах, шаардлагатай багаж хэрэгслээр тоногдсон байх

Засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаанаас гарсан аюултай хог хаягдлыг зориулалтын бэлтгэсэн талбайд хадгалан бүртгэл хөтөлдөг. Тайлант онд засвар үйлчилгээний төвийн үйл ажиллагаанаас 3 удаагийн асгаралт үүссэн ба бохирдсон хөрсийг тэр даруй хуулж авч цэвэрлэн, саармагжуулах арга хэмжээ авч ажилласан.



Зураг 10. Хөрсөнд асгарсан аюултай хог хаягдлыг цэвэрлэж байгаа нь

5.10 Уурхай орчмын барилга байгууламжуудыг тойруулан хашсан торон хашааны бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах ба нурж эвдэрсэн тохиолдолд засаж мал, амьтан нэвтрэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх

Барилга байгууламжийг тойруулан хашсан хашааны бүрэн бүтэн байдал, уурхайн талбай, ногоон байгууламжид мал орохоос сэргийлж уулын мастер, аж ахуйн ажилтнууд байнгын хяналт тавьж ажилладаг.

5.11 Цаг агаар хүндэрч бэлчээр нутгийн ан амьтан идэш тэжээлээр дутмаг үед мал амьтдад өвс, тэжээл тавьж өгөх зэргээр зориудын тэтгэх (биотехникийн) арга хэмжээ авах

Ан амьтан хамгаалах, идэш тэжээлээр хангах зорилгоор Баянжаргалан сумын ЗДТГазарт 200 боодол өвс хүлээлгэн өгсөн. /Өвс хүлээлгэн өгсөн актыг [ЭНД](#) дарж харна уу./




Зураг 11. Өвс хүлээлгэн өгч байгаа нь

5.12 Уурхайн талбай орчимд харагдсан амьтадын бүртгэлийг уурхайн ажилчдын оролцоотойгоор бүртгэн амьтдын тархалт, байршлын талаар мэдээллийг цуглуулах

Уурхайн талбайн орчимд үзэгдсэн амьтдын бүртгэлийг хийж сар бүр ERP системд оруулан мэдээллийн сан үүсгэсэн. Нийт 57 бодгаль бүртгэгдсэн ба туулай, зараа, гүрвэл элбэг тааралдсан.

#	Үйлдвэр, уурхай	Он сар	Ажиллагсан огноо, цаг	Ан амьтан	Харагдсан тоо	Хүлс	Бүртгэсэн
1	Хөөтийн уурхай	2023/10	2023/09/12 11:10:59	Црокор хоньны гүрвэл	4	Тодорхойгүй	ГЭРЭЛТҮҮЯА Б [ХУ]
2	Хөөтийн уурхай	2023/10	2023/09/27 17:30:09	Шар үнэг	2	Тодорхойгүй	ГЭРЭЛТҮҮЯА Б [ХУ]
3	Хөөтийн уурхай	2023/10	2023/09/08 20:15:17	Далдэн зараа	2	Тодорхойгүй	ГЭРЭЛТҮҮЯА Б [ХУ]
4	Хөөтийн уурхай	2023/10	2023/09/28 18:00:40	Хорс	1	Тодорхойгүй	ГЭРЭЛТҮҮЯА Б [ХУ]
5	Гөттөнийн уурхай	2023/09	2023/03/31 08:40:43	Далдэн зараа	2	Тодорхойгүй	БАТСАЙМАН Э [ИЦ]
6	Гөттөнийн уурхай	2023/09	2023/03/31 08:39:04	Хар хэрэг	4	Тодорхойгүй	БАТСАЙМАН Э [ИЦ]
7	Гөттөнийн уурхай	2023/09	2023/03/31 08:37:52	Бор туулай	3	Тодорхойгүй	БАТСАЙМАН Э [ИЦ]
8	Хөөтийн уурхай	2023/09	2023/07/22 14:00:00	Црокор хоньны гүрвэл	3	Тодорхойгүй	ГЭРЭЛТҮҮЯА Б [ХУ]
9	Хөөтийн уурхай	2023/09	2023/07/10 19:20:13	Далдэн зараа	2	Тодорхойгүй	ГЭРЭЛТҮҮЯА Б [ХУ]
10	Хөөтийн уурхай	2023/09	2023/07/13 11:00:14	Хорс	1	Тодорхойгүй	ГЭРЭЛТҮҮЯА Б [ХУ]
11	Хөөтийн уурхай	2023/09	2023/07/08 17:57:39	Бор туулай	1	Тодорхойгүй	ГЭРЭЛТҮҮЯА Б [ХУ]



Зураг 12. Амьтны үзэгдэл болон ERP системд бүртгэсэн байдал

6. НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 7. Нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг тусгай дансанд байршуулах	Уурхайн хэмжээнд	Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг БОАЖЯ-ны тусгай дансанд байршуулсан.	18,320,000.0	Тухайн жилдээ
2	Уурхайн суурингийн ногоон байгууламжийг арчлан тордож, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Уурхайн талбайд	2023 оны 4 дүгээр сараас ногоон байгууламжийн усалгааг эхлүүлсэн ба уурхайн хотхоны өргөтгөлд 1030 ширхэг мод тарьж арчилгаа, усалгааг өдөр бүр хийж гүйцэтгэсэн.	3,005,365.0	Тухайн жилдээ
3	Уурхайн хашаан доторх газрын ургамалжуулах арга хэмжээг жил бүр хэрэгжүүлэх	Уурхайн хотхон	Уурхайн хотхоны өргөтгөлийн хэсгийн 1240.55м2 талбайг зүлэгжүүлэн, оффис, амрах байрны урдуур нэг наст цэцэг тарьсан.	400,000.0	Тухайн жилдээ
Нийт зардал				21,725,365.0	

6.1 Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг тусгай дансанд байршуулах

Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардал болох 18,320,000 төгрөгийг БОАЖЯ-ны тусгай дансанд байршуулсан. /Гүйлгээ хийсэн баримтыг [ЭНД](#) дарж харна уу./

6.2 Уурхайн суурингийн ногоон байгууламжийг арчлан тордож, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх

2023 оны 4 дүгээр сараас ногоон байгууламжийн усалгааг эхлүүлсэн ба уурхайн хотхоны өргөтгөл болон нөхөн тарилтаар 6 төрлийн нийт 1030 ширхэг мод тарьж арчилгаа, усалгааг өдөр бүр хийж гүйцэтгэсэн.



Зураг 13. Уурхайн ногоон байгууламж

6.3 Уурхайн хашаан доторх газрын ургамалжуулах арга хэмжээг жил бүр хэрэгжүүлэх

Уурхайн хотхоны өргөтгөлийн хэсгийн 1240.55м² талбайг зүлэгжүүлэн, оффис, амрах байрны урдуур нэг наст цэцэг тарьсан.



Зураг 14. Уурхайн хотхоны өргөтгөлийн зүлэгжүүлэлт, нэгт наст цэцэг тарьсан байдал

7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 8. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
---	--------------------------------------	--------------	-----------------	-----------------------	--------------------

1	Сумын нутаг дэвсгэрт мод тарьж, ногоон байгууламж нэмэгдүүлэх	Орон нутгийн саналын дагуу	Баянжаргалан сумын наадмын талбайн хойно 225 ширхэг улиас мод тарьж, 300 ширхэг хайлаас мод хандивласан.	36,712,800.0	Тухайн жилдээ
Нийт зардал				36,712,800.0	

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Дундговь аймгийн Баянжаргалан сумын Наадмын талбайн хойно 2023 оны 05 дугаар сарын 15, 16-ны өдөр 225 ширхэг улиас мод тарьж, усалгаа арчилгааг тогтмол хийж, гүний худгийг засварлан ашиглалтанд оруулсан.



Зураг 15. Мод тарилт болон ургалтын байдал


8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 9. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Иргэний саналын дагуу нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох талаар судлах	Нөлөөллийн бүс дэх өрх	Нөлөөллийн бүсэд оршин суух иргэний хүсэлтийн дагуу эд хөрөнгийн харьцуулсан судалгааг хийж Ерөнхийлөгчид	50,300,000.0	Тухайн жилдээ

		танилцуулан зөвшөөрөл авч Нөхөн төлбөр олгох гэрээ байгуулан нүүлгэн шилжүүлэх асуудлыг шийдвэрлэсэн.	
Нийт зардал			50,300,000.0

Уурхайн нөлөөллийн бүсэд оршин суух иргэн Б.Ууганцэцэгийн эд хөрөнгийн үнийн судалгааг цахим эх үүсвэр ашиглан хийж удирдлагуудад танилцуулан иргэний хүсэлтийг шийдвэрлэх зөвшөөрлийг авсан. Иргэний хүсэлтийн дагуу Нөхөн төлбөр төлөх гэрээг 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдөр байгуулан нүүлгэн шилжүүлэх асуудлыг шийдвэрлэсэн.



Зураг 16. Иргэний хүсэлт, нөхөн төлбөр төлөх гэрээ

9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд түүх, соёлын өв дурсгалууд илрээгүй тул арга хэмжээ төлөвлөөгүй болно.

10. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Технологийн хэвийн ажиллагааны горим алдагдах, тоног төхөөрөмжүүдэд эвдрэл, доголдол гарахаас урьдчилан сэргийлж үзлэг оношилгоог тогтмол хийх, байнгын хяналт тавих	Уурхайн хэмжээнд	Үзлэг оношлигоог тогтмол хийж эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд засварлаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш

2	Уурхайн цахилгаан тоног төхөөрөмж, өндөр хүчдэл зэрэгтэй харьцан ажиллаж буй хүн мэргэжлийн хүн байх, мэргэжлийн бус хүн түүгээр оролдох, харьцаж ажиллахыг хатуу хориглох	Нийт ажилтан	Цахилгааны эвдрэл гэмтлийг цахилгааны инженер, цахилгаанчин, диспичерүүд засаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
3	Мэргэшиж дадаагүй ажилчдыг удирдлагын заавар, зөвшөөрөлгүй, бусдын гуйлт хүсэлтээр буюу дур мэдэн ажил гүйцэтгүүлэхгүй байх, осол аваар гарахаас урьдчилан сэргийлэх	Нийт ажилтан	Ажил эхлэхээс өмнө ажилчдын хийх ажил болон аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгдөг.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
4	Өндөр хүчдэл, цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцан ажиллаж буй хүнийг багаж хэрэгсэл, хамгааллын хувцсаар бүрэн хангах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг чанд мөрдүүлэн ажиллах	Нийт ажилтан	Цахилгаанчин, диспичерүүдэд ажил эхлэхээс өмнө хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, хувцас хэрэгслээр ханган аюулгүй ажиллагаанд байнгын хяналт тавьж ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
5	Чийгтэй орчинд цахилгаан тоног төхөөрөмж, өндөр хүчдэлтэй харьцан ажиллавал богино холбоо үүсэх эрсдэлтэй тул урьдчилан сэргийлэх үүднээс хур тунадас, чийгтэй үед ажилчдыг ажиллуулахгүй байх	Нийт ажилтан	Хур тунадас орсон үед цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцах ажлыг зогсоодог.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
6	Цахилгаан хэрэгслийн хүчдэлийг салгалгүй засвар үйлчилгээ хийж хүчдэлд цохиулахаас байнга урьдчилан сэргийлэх	Нийт ажилтан	Тоног төхөөрөмж болон удирдлагын самбарыг хүчдэлгүй болгон ажлын байр бэлдэж хүчдэлд цохиулахаас урьдчилан сэргийлсэн.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш

7	Цахилгаан тоног төхөөрөмжид байнгын үзлэг үйлчилгээ хийх, ашиглалтын заавар зөрчихгүй байх	Нийт ажилтан	Цахилгаанчин 1,2-р шатны үзлэг болон 04кВ-ын үзлэгийг өдөр тутам, цахилгааны инженер 3,4-р шатны үзлэгийг сард 2 удаа хийсэн.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
8	Аюулгүйн зайлшгүй буюу мэдээжийн арга хэмжээ авалгүй эсвэл аваагүй байхад ажилд яаравчлан орохгүй байх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мөрдөн ажиллах	Нийт ажилтан	Аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж ажил эхлэхийн өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа, дүрмийг танилцуулан, хэрэгжилтэнд байнгын хяналт тавьж ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
9	Өндөр даралт, температур, хүчдэлийг бүрэн буусан эсэхийг байнга шалган магадлах, түүний үндсэн дээр ажилд орох, завсар үйлчилгээ хийх	Нийт ажилтан	Удирдлагын хэлхээг салгаж ажлын байр бэлдэж зөөврийн болон тоноглолын газардуулгыг тавьсны дараагаар ажлыг эхлүүлдэг.	Үйл ажиллагааны зардлаас	Жилийн турш
Нийт зардал				-	

10.1 Технологийн хэвийн ажиллагааны горим алдагдах, тоног төхөөрөмжүүдэд эвдрэл, доголдол гарахаас урьдчилан сэргийлж үзлэг оношилгоог тогтмол хийх, байнгын хяналт тавих

Уурхайн тоног төхөөрөмжүүдэд хариуцсан инженер техникийн ажилчид байнгын хяналт тавин ажилладаг ба шүүрлийн усны насост гарсан эвдрэлийг Баянжаргалан сумын байгаль орчны мэргэжилтэнг байцуулан 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр засаж суурилуулсан. /Шүүрлийн усны насосны тоолуур сольж суурилуулсан актыг [ЭНД](#) дарж харна уу/

10.2 Уурхайн цахилгаан тоног төхөөрөмж, өндөр хүчдэл зэрэгтэй харьцан ажиллаж буй хүн мэргэжлийн хүн байх, мэргэжлийн бус хүн түүгээр оролдох, харьцаж ажиллахыг хатуу хориглох

Цахилгааны эвдрэл гэмтлийг цахилгааны инженер, цахилгаанчин, диспичерүүд хариуцан засах ба Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн анхан болон давтан зааварчилгаагаар мэргэжлийн бус хүн цахилгаан, өндөр хүчдэлтэй харьцан ажиллахыг хориглох талаар сургалтыг нийт ажилчдад орж танилцуулдаг. Тайлант онд нийт 4 удаагийн багц сургалтыг давхардсан тоогоор 130 ажилтанд орсон.

10.3 Мэргэшиж дадаагүй ажилчдыг удирдлагын заавар, зөвшөөрөлгүй, бусдын гуйлт хүсэлтээр буюу дур мэдэн ажил гүйцэтгүүлэхгүй байх, осол аваар гарахаас урьдчилан сэргийлэх

Өдөр бүр ажил эхлэхийн өмнө нийт ажилчид аюулгүй ажиллагааны нярад авч ажил үүргээ гүйцэтгэдэг ба тайлант онд ажлын байран дахь осол, гэмтэл бүртгэгдээгүй болно.



Зураг 17. Цахилгаан, механик, уулын хэсгийн аюулгүй ажиллагаа, ажлын нярад өгсөн байдал

10.4 Өндөр хүчдэл, цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцан ажиллаж буй хүнийг багаж хэрэгсэл, хамгааллын хувцсаар бүрэн хангах, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг чанд мөрдүүлэн ажиллах

Цахилгаанчин, диспичерүүдэд ажил эхлэхээс өмнө хөдөлмөрийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, хувцас хэрэгслээр ханган аюулгүй ажиллагаанд байнгын хяналт тавьж ажилласан.



Зураг 18. Нарядны дэвтэр, хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгсэл

10.5 Чийгтэй орчинд цахилгаан тоног төхөөрөмж, өндөр хүчдэлтэй харьцан ажиллавал богино холбоо үүсэх эрсдэлтэй тул урьдчилан сэргийлэх үүднээс хур тунадас, чийгтэй үед ажилчдыг ажиллуулахгүй байх


Хур тунадас орсон үед цахилгаан тоног төхөөрөмжтэй харьцах ажлыг зогсоодог.

10.6 Цахилгаан хэрэгслийн хүчдэлийг салгалгүй засвар үйлчилгээ хийж хүчдэлд цохиулахаас байнга урьдчилан сэргийлэх

Тоног төхөөрөмж болон удирдлагын самбарыг хүчдэлгүй болгон ажлын байр бэлдэж хүчдэлд цохиулахаас урьдчилан сэргийлдэг ба үүнд ХЭМАБ инженер, цахилгааны инженер хяналт тавин ажилладаг.

10.7 Цахилгаан тоног төхөөрөмжид байнгын үзлэг үйлчилгээ хийх, ашиглалтын заавар зөрчихгүй байх

Цахилгаанчин 1,2-р шатны үзлэг болон 04кВ-ын үзлэгийг өдөр тутам, цахилгааны инженер 3,4-р шатны үзлэгийг сард 2 удаа хийсэн.



Зураг 19. Үзлэг хийсэн тэмдэглэл

10.8 Аюулгүйн зайлшгүй буюу мэдээжийн арга хэмжээ авалгүй эсвэл аваагүй байхад ажилд яаравчлан орохгүй байх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мөрдөн ажиллах

Уурхайн нийт ажилчдад MNS4969:2000 стандарт болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/370 тоот тушаалын дагуу ХАБЭА-н сургалт, зааварчилгааг байнга ордог. Үүнд:

Хүснэгт 11. ХАБЭА-н чиглэлээр ордог сургалт, түүний давтамж

№	ХАБЭА зааварчилгаа	Давтамж	
1	Урьдчилсан зааварчилгаа	Шинэ ажилчдад	
2	Ажлын байран дахь анхан шатны зааварчилгаа	Шинэ болон ажлын байрны нөхцөл өөрчлөгдсөн ажилчдад	
3	Давтан зааварчилгаа	Ээлжит	Улирал тутам
4		Ээлжит бус	Тухай бүрт
5		Өдөр тутмын	Өдөр бүр
6	Шинэ ажилтны сургалт	Шинэ ажилчдад	
7	Нийт ажилтны сургалт	Жилд 2 удаа	
8	Ажил олгогчийн сургалт	Жилд 1 удаа	
9	Эрсдэлтэй ажлын байрны сургалт	2 жилд 1 удаа	
10	Тусгай сургалт	Тухай бүрт	

Тайлант онд нийт 4 удаагийн багц сургалтанд давхардсан тоогоор 130 ажилтан хамрагдсан байна.



Зураг 20. ХАБЭА-н сургалт орж байгаа нь

10.9 Өндөр даралт, температур, хүчдэлийг бүрэн буусан эсэхийг байнга шалган магадлах, түүний үндсэн дээр ажилд орох, завсар үйлчилгээ хийх

Удирдлагын хэлхээг салгаж ажлын байр бэлдэж зөөврийн болон тоноглолын газардуулгыг тавьсны дараагаар ажлыг эхлүүлдэг. Дээрх ажил гүйцэтгэх явцад ХЭМАБ инженер, цахилгааны инженер байнгын хяналт тавин, аюулгүй ажиллагааны заавраар ханган ажилладаг.

11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Энгийн хог хаягдлаа ангилан ялгах, хог хаягдлын цэгийг стандарт шаардлагын дагуу байгуулах, шаардлага хангасан ангилан ялгах хогийн сав байршуулах	Уурхайн хэмжээнд	Хог хаягдал ангилан ялгах хогийн цэг байгуулсан.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
2	Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах, үүссэн хог хаягдлаа тогтмол зайлуулах		2023 оны 1 дүгээр сард Сумын Засаг даргатай хог хаягдлын гэрээг байгуулан үүссэн хог хаягдлаа сумын төвийн хогийн цэгт хаяж байна.	960,000.0	Жилдээ
3	Ажилчдад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, сургалт зохион байгуулах		Уурхайн 1 болон 2-р ээлжний ажилчдад хог хаягдлын ангилан ялгалт, менежментийн тухай сургалтыг зохион байгуулсан.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ

4	Үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгахдаа үйл ажиллагаатай холбоотой хяналт тавих	Уурхайн хэмжээнд мөрдөх Хог хаягдлын журам, процессын зураглалыг уурхайн даргаар батлуулан журмын хэрэгжилт, хог хаягдлын менежментийн хэрэгжилтэнд байнгын хяналт тавин ажиллаж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр
5	Тос тосолгооны материалын үлдэгдэл хаягдлыг ил задгай хаяхгүй байх, тусгай талбайд зориулалтын битүүмжлэлтэй цэгт хуримтлуулах	Хаягдал тос маслыг зориулалтын бэлтгэсэн талбайд хадгалж, бүртгэл хөтөлж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Жилдээ
Нийт зардал			960,000.0	

11.1 Энгийн хог хаягдлаа ангилан ялгах, хог хаягдлын цэгийг стандарт шаардлагын дагуу байгуулах, шаардлага хангасан ангилан ялгах хогийн сав байршуулах


Уурхайн хэмжээнд хог хаягдлын хэмжээг бууруулах, дахин ашиглах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах цэгийг ахуйн, дахивар, бусад гэсэн 3 хэсэгт хуваан байгуулсан.



Зураг 21. Энгийн хог хаягдлын ангилан ялгах, түр хадгалах цэг

11.2 Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах, үүссэн хог хаягдлаа тогтмол зайлуулах

2023 оны 1 дүгээр сард Сумын Засаг даргатай хог хаягдлын гэрээг байгуулан үүссэн хог хаягдлаа сумын төвийн хогийн цэгт хаяж байна.



Зураг 22. Хог хаягдлын гэрээ, хог хаяж буй байдал

11.3 Ажилчдад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх, сургалт зохион байгуулах

Уурхайн нийт ажилчдад байгаль орчны бохирдлоос урьчдлан сэргийлэх, үүсч буй хог хаягдлаа хэрхэн ангилан ялгах талаар мэдлэг олгох, уурхайн даргын баталсан “Хог хаягдлын менежментийн журам” танилцуулах зорилгоор сургалтыг зохион байгуулан хэрэгжилтэнд байнгын хяналт тавин ажиллаж байна.



Зураг 23. Уурхайн ажилчдад сургалт орж байгаа нь

11.4 Үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгахдаа үйл ажиллагаатай холбоотой хяналт тавих

Уурхайн хэмжээнд мөрдөх Хог хаягдлын журам, процессын зураглалыг уурхайн даргаар батлуулан журмын хэрэгжилт, хог хаягдлын менежментийн хэрэгжилтэнд байнгын хяналт тавин ажилладаг. Мөн үүссэн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж 65 кг хаягдал хуванцар, картонан цаасыг аймгийн дахивар авах цэгт тушаан, ахуйн хог хаягдлыг сумын төвийн хогийн цэгт хаяж байна. /Дахивар хүлээлгэн өгсөн актыг [ЭНД](#) дарж харна уу/



Зураг 24. Хаягдал хуванцар сав, картонан цаас хүлээлгэн өгч байгаа нь

**11.5 Тос тосолгооны материалын үлдэгдэл хаягдлыг ил задгай хаяхгүй байх,
тусгай талбайд зориулалтын битүүмжлэлтэй цэгт хуримтлуулах**

Засвар үйлчилгээний төвөөс үүсч буй аюултай хог хаягдлыг зориулалтын бэлтгэсэн талбайд хадгалж, сар бүр бүртгэл хөтлөдөг. Тайлант онд уурхайн аюултай хог хаягдал түр хадгалах цэгт төвлөрсөн 2 тн хаягдал тос маслыг аюултай хог хаягдал дахин боловсруулах, устгах тусгай зөвшөөрөлтэй Түмэн эгшиг ХХК-д хүлээлгэн өгсөн. /Аюултай хог хаягдлын гэрээ, дагалдах маягтыг [ЭНД](#) дарж харна уу/



Зураг 25. Аюултай хог хаягдал хадгалах талбай

12. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТЫН БИЕЛЭЛТ

Хүснэгт 13. Байгаль орчны төлөвлөгөөт аудитын биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Байгаль орчны чиглэлийн үйл ажиллагааны хуулийн хэрэгжилт, нийцлийг тогтоох	Уурхайн хэмжээнд	Энвйронментал комплайнц ХХК нь байгуулсан гэрээний дагуу 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдөр хийж гүйцэтгэсэн.	11,100,333.0	Жилдээ
Нийт зардал				11,100,333.0	

Байгаль орчны аудитыг Энвйронментал комплайнц ХХК 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 20-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн. Аудитын дүгнэлтээр хууль эрхзүйн нийцэл 99,5%-тай үнэлэгдсэн ба зөвлөмж байхгүй болно. /Аудитын дүгнэлтийг [ЭНД](#) дарж харна уу/

13. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

13.1 Усны хяналт шинжилгээ

Хүснэгт 14. Усны хяналт шинжилгээний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Ca, Mg, CL, SO4, NO2, K агууламж, амт, үнэр, өнгө, рН нийт ууссан хатуу бодисын хэмжээ, нийт хатуулаг	Унд, шүүрлийн ус	Унд, шүүрлийн уснаас дээж авч Дундговь аймгийн УЦУОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораториор химийн шинжилгээг гүйцэтгүүлсэн.	440,000.0	Жилд 2 удаа
Усны хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал				440,000.0	

Уурхайн ундны уснаас 6, 10-р сард дээж авч итгэмжлэгдсэн Усны төв лаборатори, Дундговь аймгийн УЦУОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораториор ерөнхий химийн шинжилгээг хийлгүүлэв. Шинжилгээний дүнг MNS0900:2018 “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага” стандарттай харьцууллаа.

Хүснэгт 15. Ундны усны-химийн үзүүлэлтийн шинжилгээний дүн

Үзүүлэлт	MNS 0900:2018 ЗДХ		
		Ундны ус	Шүүрлийн ус
рН-Усны орчин	6.5-8.5	8.03	7.3
Цахилгаан дамжуулах чанар мСм\см	-	931	8740
Ерөнхий хатуулаг мг-экв\л	<7.0	7.02	43.68
Кальци, (Ca ²⁺) мг\л	<100.0	67.1	234.5

Магни, (Mg ²⁺) мг\л	<30.0	44.6	388.9
Фосфатын ион, (PO ₄ ³⁻) мг\л	3.5	0.003	0.011
Хлорид (Cl) мг\л	<350.0	61	716.1
Гидрокарбонат (HCO ₃) мг\л	-	366.1	1183.7
Нитритийн ион (NO ₂), мг\л	<1.0	0	0.009
Нитрат (NO ₃), мг\л	<50.0	2.41	0.96
Сульфат, (SO ₄) мг\л	<500.0	165.2	2216
Төмөр (Fe), мг\л	0.3	0.22	0.16
Натри, Кали (Na, K) мг\л	<200	103.5	1051.5
Аммони, (NH ₄) мг\л	<1.5	0.35	13.75

Шинжилгээний дүнг MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандарттай харьцуулахад ундны ус стандартын шаардлага хангаж байна.

Харин шүүрлийн ус эрдэсжилт, хатуулаг ихтэй нь харагдаж байна. Шүүрлийн усыг ногоон байгууламж, зам усалгаанд ашигладаг болно. (Лабораторийн шинжилгээний хариуг [ЭНД](#) дарж харна уу)



Зураг 26. Дээж авч буй байдал

13.2 Хөрсний хяналт шинжилгээ

Хүснэгт 17. Хөрсний хяналт шинжилгээний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Хөрсний хими физик шинж чанар	Шимт хөрсний овоолго, Уурхайн карьер, Хотхон, Хогийн цэг	Хөрсний агрохими, хүнд металлын шинжилгээг нийслэл болон Дундговь аймгийн УЦУОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораториор гүйцэтгүүлсэн.	1,935,200.0	Хавар, Намар
2	Хөрсний хүнд металл (Cr, Cd, Pb, Ni, Zn агууламж)				Хавар, Намар
Хөрсний хяналт шинжилгээний хөтөлбөрийн нийт зардал				1,935,200.0	

13.2.1 Хөрсний хими физик шинж чанар

Уурхайн хөрсний бохирдлыг хянах зорилгоор 6, 10-р сард дээж авч нийслэл болон Дундговь аймгийн УЦУОШТөвийн байгаль орчны шинжилгээний лабораториор хийлгүүлсэн.

Хүснэгт 18. Хөрсний шинжилгээний дүн

Дээжний нэр	Хотхон	Шимт хөрсний овоолго	Уурхайн карьер	Хогийн цэг
pH	8.1	7.9	6.72	8.32
Ялзмаг %	0.07	0.28	0.45	0.28
NO ₃ мг/кг	6.9	8.8	23.8	25.8
NH ₄ мг/кг	39.6	48.4	79.2	24.6
SO ₄ мг/кг	96.2	1047.9	1471.9	81
P ₂ O ₅ мг/кг	илр	илр	илр	илр

Хүснэгт 19. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн

№	Цэгийн нэр	Hg	Cd	Pb	Cu	Zn	Cr	Sr
		ppm	ppm	ppm	ppm	ppm	ppm	ppm
1	Шимт хөрсний овоолго	<0.005	0.1	12	29	62	<0.005	331
2	Хотхон	<0.005	0.5	11	29	<0.005	<0.005	342
3	Уурхайн карьер	<0.005	0.4	13	29	52	7.8	334
4	Хогийн цэг	<0.005	<0.005	10	30	35	<0.005	295
Хүлцэх агууламж /MNS 5850:2019/		150	3,0	100,0	100,0	300,0	150,0	800,0
Хортой агууламж /MNS 5850:2019/		1000,0	10,0	500,0	400,0	500,0	600,0	3000,0
Аюултай агууламж /MNS 5850:2019/		1800,0	20,0	1200,0	1500,0	1000,0	1000,0	6000,0

Шинжилгээний дүнгээс харахад MNS5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартад заагдсан хэмжээнд байна. (Лабораторийн шинжилгээний хариуг ЭНД харна уу)



Зураг 27. Хөрсний дээж авч буй байдал

13.3 Агаарын хяналт шинжилгээ

Хүснэгт 20. Агаарын хяналт шинжилгээний биелэлт




№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Тоосжилт	Технологийн зам, уурхайн карьер, ажилчдын хотхон, нөлөөллийн бүс	Тоосны концентрацийн хэмжилтийг 06, 10-р сард хийлгэсэн бөгөөд шинжилгээний дүнг доор дэлгэрэнгүй харуулав.	120,000.0	Хавар, намар
2	SO ₂ , NO ₂		Агаарын чанарын шинжилгээг 06, 10-р сард хийлгэсэн бөгөөд шинжилгээний дүнг доор дэлгэрэнгүй харуулав.	298,000.0	
Агаарын чанарын хяналт шинжилгээний нийт зардал мян.төг				418,000.0	

Уурхайн гадаад орчны агаарын чанарын шинжилгээг Дундговь аймгийн УЦОШТөвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор хийлгэсэн. Ингэхдээ уурхайн карьер, технологийн зам, ажилчдын хотхон, нөлөөллийн бүс гэсэн объектуудад угаарийн хий, азотын давхар исэл, агаарын нийт тоосонцрыг тодорхойлох шинжилгээнүүдийг хийлгэсэн. Шинжилгээний үзүүлэлтүүдийг агаарын чанарын MNS4585:2016 стандарттай харьцуулахад уурхайн карьер болон технологийн замын нийт тоосны хэмжээ стандартаас давсан тул зам усалгааны давтамжийг нэмэгдүүлж өдөрт 3 удаа усалгаа хийсэн. (Лабораторийн шинжилгээний хариуг [ЭНД](#) харна уу)

Хүснэгт 21. Агаарын шинжилгээний дүн

№	Сорьц авсан цэг	SO ₂ мг/м ³	NO ₂ мг/м ³	Нийт тоос мг/м ³
1	Уурхайн карьер	0.016	0.028	1.870
2	Технологийн зам	0.015	0.023	1.090
3	Ажилчдын хотхон	0.013	0.018	0.025
4	Нөлөөллийн бүс	0.017	0.038	0.017
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016		0.450 мг/м³	0.20 мг/м³	0.50 мг/м³

График 4. Агаарын чанарын харьцуулалт





Зураг 28. Агаарын чанарын дээжлэлт хийж буй байдал

13.4 Ургамлан бүрхэвчийн судалгаа

Хүснэгт 22. Ургамлан бүрхэвчийн судалгааны биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал /мян.төг/	Биелэлтийн шалгуур
1	Ургамлын зүйлийн бүрдэл (овог, төрөл, зүйл) Бодгалийн тоо Дундаж өндөр, см Бүрхэц	Төслийн талбайд	Ургамлан бүрхэвчийн судалгааг мониторингийн 2 цэгт хийж гүйцэтгэсэн.	200,000.0	Жилд 1 удаа
Нийт зардал				200,000.0	

Ургамлын судалгааг жилд нэг удаа 8 сард хийхээр төлөвлөсний дагуу 2022.08.17-ны өдөр раменскийн тор ашиглан MV-012199, MV-020297 тусгай зөвшөөрлийн талбайн ургамлын мониторингийн 2 цэгт хийж гүйцэтгэсэн. Ургамлан бүрхэвчийн судалгаагаар тухайн цэгүүд дахь ургамлын зүйлийн бүрдэл, бодгалийн тоо, газрын дээрх ургамлын өндөр болон бүрхэцийг тодорхойлох боломжтой.

Хүснэгт 23. Ургамлын зүйлийн бүрдэл

№	Мониторингийн цэгийн байршил	Ургамлын зүйл		Бодгалийн тоо	Амьдралын хэлбэр	Наслалт	Бодгалийн өндөр [см]	Ургамлын бүрхэц	Зүйлийн тоо
		Латин	Монгол						
1	MV-012199 45°41'1.00"N, 107°40'54.00"E	Allium polyrhizum	Таана	9	Өвслөг ургамал	Олон наст	21	48%	4
2		Reaumuria soongorica (Pall.)	Зүүнгарын улаан бударгана	3	Сөөглөг ургамал	Олон наст	11		
3		Reaumuria soongorica L.	Ишгэн шарилж	1	Өвслөг ургамал	Олон наст	12		
4		Eragrostis	Бага	2	Өвслөг	Нэг	15		

		minor Host	хургалж		ургамал	наст			
5	MV-020297 45°42'15.00"N, 107°39'46.00"E	Allium polyrhizum	Таана	6	Өвслөг ургамал	Олон наст	19	37%	3
6		Reaumuria soongorica (Pall.)	Зүүнгарын улаан бударгана	1	Сөөглөг ургамал	Олон наст	10		
7		Bassia dasyphylla (Fisch. Et Mey.) Ktze.	Үслэг манан хамхаг	8	Өвслөг ургамал	Нэг наст	12		



Зураг 29. Уурхайн орчим бичиглэл хийж буй байдал

Тусгай зөвшөөрлийн 2 талбайд ургамлан бүрхэвчийн судалгааг хийхэд олон наст өвслөг ургамал зонхилох ба ургамлын бүрхэц сийрэг байгаа нь харагдаж байна.

13.5 Амьтны аймгийн хяналт шинжилгээ

Уурхайн талбайгаас 10км радиуст амьтны мониторингийг хийхэд жижиг хөхтөн амьтдаас туулай, зараа, хэвлээр явагчдаас хонин гүрвэл, том хөхтөн амьтдаас цагаан зээр элбэг үзэгдсэн. Амьтдын бүртгэлийг хийж ERP системд оруулан мэдээллийн сан үүсгэсэн.



Зураг 30. Амьтны үзэгдлийн бүртгэл

13.6 Дуу шуугианы хэмжилт


Дуу шуугианы хэмжилтийг дотооддоо III, IV улиралд мониторингийн 4 цэгт PSE-EM 883 багажаар загварын багажаар хийж гүйцэтгэсэн. Энэхүү багаж нь 30-160 дБ-ийн хоорондох дуу чимээний утгыг хэмждэг. Хэмжилтийн утгыг “Хөдөлмөрийн аюулгүй

байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь шуугианы өртөлтийн хэмжилт, зөвшөөрөгдөх дээд хэмжээ, ажилтны сонголт хамгаалахад тавих ерөнхий шаардлага” MNS 6768:2019 стандарттай харьцуулав.

Хүснэгт 24. Дуу шуугианы хэмжилтийн дүн

Цэгүүдийн байршил	6-р сар	7-р сар	8-р сар	9-р сар	10-р сар
Хөрсний овоолго	50.2	54.2	48.3	53.2	68.8
Уурхайн хотхон	35.5	39	41.1	56.9	43.8
Засвар үйлчилгээний төв	51.6	51.8	56.3	58.8	65.2
Уурхайн карьер	59.6	65.4	68.4	67.5	59.9
MNS 6768:2019	83				

График 5. Стандарттай харьцуулсан дүн



Хэмжилтийн дүнг MNS 6768:2019 стандарттай харьцуулахад ЗДХ-ээс хэтэрсэн үзүүлэлт ажиглагдахгүй байна.

14. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 25. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан холбогдох газраар батлуулж, биелэлтийг хангах	Уурхайн хэмжээнд	2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан БОАЖЯ-р батлуулан, биелэлтийг ханган ажилласан.	Үйл ажиллагааны зардлаас	Хуваарийн дагуу хийх
2	Ус ашиглах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээг байгуулах гүйцэтгэлийг хангах, төлбөрийг төлөх		Уурхайн ус ашиглах дүгнэлтийг гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээ байгуулан төлбөрийг төлсөн.	15,860,956.5	
3	Хаягдал бохир усны дүгнэлт, хаягдал бохир		Уурхайн хаягдал бохир усны дүгнэлт,	218,137.5	

	ус зайлуулах зөвшөөрөл, гэрээг байгуулах, гүйцэтгэлийг хангах, төлбөрийг төлөх	зөвшөөрлийг авч гэрээг байгуулан төлбөрийг төлж гүйцэтгэлийг ханган ажилласан.	
4	Мэргэжлийн байгууллагатай хамтран хог хаягдлыг тээвэрлэн, зайлуулах гэрээг хийж, гүйцэтгэлийг хангах	Уурхайн хог хаягдлын гэрээг хийж төлбөрийг төлсөн.	Үйл ажиллагааны зардлаас
5	2 жил тутамд байгаль орчны төлөвлөгөөт аудитын ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Байгаль орчны хөндлөнгийн төлөвлөгөөт аудитыг Энвйронментал комплайнц ХХК-р гүйцэтгүүлсэн.	Үйл ажиллагааны зардлаас
6	Төслийн хэмжээнд бүхэлд нь Гамшгийн эрсдэлийн үнэлгээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан, батлан хэрэгжүүлэх	Уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хийлгэж батлуулсан.	Үйл ажиллагааны зардлаас
7	Байгаль орчны сургалт семинарыг зохион байгуулж, түүнд хамруулах	Байгаль орчны сургалтыг нийт ажилчдад орсон.	Үйл ажиллагааны зардлаас
8	Харилцаа мэдээлэл /янз бүрийн түвшин ба ажил үүргийн хоорондын дотоод харилцаа мэдээлэл, гаднын сонирхогч талуудаас ирүүлсэн холбогдох харилцаа мэдээллийг хүлээн авах, баримтжуулах ба түүнд хариу өгөх/	Уурхайд ирсэн албан бичгүүдийг хүлээн авч биелэлтийг ханган шийдвэрлэсэн.	Үйл ажиллагааны зардлаас
9	Байгаль орчны суурь нөхцөлд өөрчлөлт гарсан эсэхэд хяналт тавьж, хэмжилт хийх	Ус, хөрс, агаарын чанарт хяналт тавьж, шинжилгээнүүдийг хийлгэсэн.	Үйл ажиллагааны зардлаас

10	Байгаль орчны суурь нөхцөл нь стандарт шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох	Ус, хөрс, агаарын чанар стандартад нийцэж байгаа эсэхийг тодорхойлсон.	Үйл ажиллагааны зардлаас
11	Байгаль орчны судалгаа үнэлгээ, хяналттай холбоотой бүртгэлийн хяналтыг байнга хөглөх	Аймаг, сумаас ирсэн хяналт шалгалтын бүртгэл хөтөлсөн.	Үйл ажиллагааны зардлаас
Нийт зардал			16,079,094.0

14.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан холбогдох газраар батлуулж, биелэлтийг хангах

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан БОАЖЯ-р батлуулан, биелэлтийг ханган ажилласан.

14.2 Ус ашиглах дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл авч, гэрээг байгуулах гүйцэтгэлийг хангах, төлбөрийг төлөх

Уурхайн ус ашиглах дүгнэлтийг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаанаас гаргуулж, зөвшөөрөл гэрээг Дундговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас авч, байгуулсан. Ус ашигласны төлбөр болох 15,860,956.5 төгрөгийг төлсөн. /Дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ, төлбөр төлсөн баримтыг [ЭНД](#) дарж харна уу/

14.3 Хаягдал бохир усны дүгнэлт, хаягдал бохир ус зайлуулах зөвшөөрөл, гэрээг байгуулах, гүйцэтгэлийг хангах, төлбөрийг төлөх

Уурхайн хаягдал бохир усны дүгнэлтийг Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаанаас гаргуулж, зөвшөөрөл гэрээг Баянжаргалан сумын Засаг даргаас авч байгуулсан. Гэрээнд заасан төлбөр болох 218,137.5 төгрөгийг төлсөн. /Дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ, төлбөр төлсөн баримтыг [ЭНД](#) дарж харна уу/

14.4 Мэргэжлийн байгууллагатай хамтран хог хаягдлыг тээвэрлэн, зайлуулах гэрээг хийж, гүйцэтгэлийг хангах

Уурхайн хог хаягдлын гэрээг Баянжаргалан сумын Засаг даргатай байгуулж 960,000 төгрөгийн төлбөрийг төлсөн. /Гэрээ, төлбөр төлсөн баримтыг [ЭНД](#) дарж харна уу/

14.5 2 жил тутамд байгаль орчны төлөвлөгөөт аудитын ажлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх

Байгаль орчны хөндлөнгийн төлөвлөгөөт аудитыг Энвйронментал комплайнц ХХК-р гүйцэтгүүлсэн. /Аудит хийх гэрээг [ЭНД](#) дарж харна уу/

14.6 Төслийн хэмжээнд бүхэлд нь Гамшгийн эрсдэлийн үнэлгээг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл

авсан эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэж, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулан, батлан хэрэгжүүлэх

Уурхайн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Дундговь аймгийн Онцгой байдлын газраар батлуулсан.

14.7 Байгаль орчны сургалт семинарыг зохион байгуулж, түүнд хамруулах

Уурхайн нийт ажилчдад 2 удаагийн багц сургалтыг усны менежмент, хог хаягдлын ангилан ялгалт, хөрсний бохирдол, ургамал, амьтан хамгаалал, компани болон уурхайн дотоод журам зэрэг сэдвүүдийн хүрээнд орсон.

14.8 Харилцаа мэдээлэл /янз бүрийн түвшин ба ажил үүргийн хоорондын дотоод харилцаа мэдээлэл, гаднын сонирхогч талуудаас ирүүлсэн холбогдох харилцаа мэдээллийг хүлээн авах, баримтжуулах ба түүнд хариу өгөх/

Уурхайд хэмжээнд дотоод болон гадны байгууллагаас ирүүлсэн албан бичиг, хүсэлтүүдийг хүлээн авч биелэлтийг ханган, хариу хүргүүлсэн.

14.9 Байгаль орчны суурь нөхцөлд өөрчлөлт гарсан эсэхэд хяналт тавьж, хэмжилт хийх

Ус, хөрс, агаарын чанарт уурхайн үйл ажиллагаанаас үзүүлж буй нөлөөллийг хянах зорилгоор жилд 2 удаа дээж авч, итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэсэн. /Шинжилгээний дүнг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэсгээс харна уу/

14.10 Байгаль орчны суурь нөхцөл нь стандарт шаардлагад нийцэж байгаа эсэхийг тодорхойлох

Ус, хөрс, агаарын чанар стандартад нийцэж байгаа эсэхийг тодорхойлж шинжилгээ хийлгэхэд технологийн замын нийт тоосны хэмжээ стандартаас давсан байсан. Иймд замын усалгааны дамтамжийг нэмэгдүүлж тоосжилтын хэмжээг бууруулсан. /Шинжилгээний дүнг орчны хяналт шинжилгээний хөтөлбөр хэсгээс харна уу/

14.11 Байгаль орчны судалгаа үнэлгээ, хяналттай холбоотой бүртгэлийн хяналтыг байнга хөтлөх

Аймаг, сумаас ирсэн хяналт шалгалтын бүртгэл хөтлөн дотоод хяналтыг тогтмол хийж гүйцэтгэсэн.

15. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Баянжаргалан сум, багийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тов одоогоор тодорхойгүй байгаа тул хурлын тов гарсан үед уурхайн үйл ажиллагаа, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг танилцуулахаар болсон.

16. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРСАН НИЙТ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардалд 36,640,000.0 төгрөг төлөвлөн тусгаж гүйцэтгэлээр 143,125,949.0 төгрөг зарцуулсан.

Хүснэгт 26. Нийт зардлын хэмжээ

№	Хийгдэх ажлын чиглэл	Хийгдсэн ажлын тодорхойлолт	Зарцуулалт, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	Уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	3,255,157.0
2	Нөхөн сэргээлт	Барьцаа хөрөнгө байршуулах, хотхоны ногоон байгууламж нэмэгдүүлэх	21,725,365.0
3	Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа	Орон нутгийн саналын дагуу	36,712,800.0
4	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор	Нөлөөллийн бүсийн айлыг нүүлгэн шилжүүлэх боломжийг судлах	50,300,000.0
5	Түүх соёлын өвийг хамгаалах	Ажил төлөвлөөгүй	-
6	Осол эрсдэлийн менежмент	Уурхайд ажиллаж буй ажилчид бэртэж, гэмтэх, гал түймэрээс сэргийлэх арга хэмжээ авах	-
7	Хог хаягдлын менежмент	Уурхайн хог цэгийг ариутгах, ангилан ялгалтыг сайжруулах	960,000.0
8	Байгаль орчны аудит	Хуулийн хэрэгжилт, нийцэл тодорхойлох	11,100,333.0
9	Орчны хяналт шинжилгээ	Усны хяналт шинжилгээ	440,000.0
		Агаарын чанарын хяналт шинжилгээ	418,000.0
		Хөрсний хяналт шинжилгээ	1,935,200.0
		Ургамлан бүрхэвч ба амьтны аймгийн судалгаа	200,000.0
10	Удирдлага зохион байгуулалт		16,079,094.0
		НИЙТ ЗАРДАЛ	143,125,949.0

17. ДҮГНЭЛТ

“Монголын алт” (МАК) ХХК нь Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн дагуу Байгаль хамгааллын дүрэм журмыг чанд сахин, стандартуудыг мөрдлөг болгон ажиллаж байгаль орчинд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, нөхөн сэргээх ажлыг тогтмол гүйцэтгэдэг билээ.

Хөөтийн уурхайн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгаалах, орчны хяналт шинжилгээ болон удирдлага зохион байгуулалтын зэрэг нийт 56 ажил төлөвлөж төлөвлөгөөний дагуу бүрэн гүйцэтгэж 100%-ийн биелэлттэй байна. Олон нийтэд тайлагнах үйл ажиллагааны хүрээнд хийгдэхээр тусгасан 3 ажлыг заасан хугацааны дагуу IV улиралд гүйцэтгэж, биелэлтийг тайлагнахаар ажиллаж байна.

2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 36,640,000.0 төгрөг төлөвлөн тусгаж, тайлант оны 10 дугаар сарын байдлаар менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргахад 143,125,949.0 төгрөг зарцуулсан байна.

18. ХАВСРАЛТУУД




1. Ус шүршигч төхөөрөмж, хөрс бэхжүүлэгч бодисын судалгаа
2. Өвс хүлээлгэн өгсөн акт
3. Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг БОАЖЯ-ны тусгай дансанд байршуулсан баримт
4. Шүүрлийн усны насосны тоолуур сольж суурилуулсан акт
5. Дахивар хүлээлгэн өгсөн акт
6. Хүлээлгэн өгсөн аюултай хог хаягдлын дагалдах маягт
7. Усны шинжилгээний дүн
8. Хөрсний шинжилгээний дүн
9. Агаарын шинжилгээний дүн
10. Ус ашиглуулах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ, төлбөр төлсөн баримт
11. Хаягдал усны дүгнэлт, зөвшөөрөл, гэрээ, төлбөр төлсөн баримт
12. Хог хаягдлын гэрээ, төлбөр төлсөн баримт
13. Аудит хийх гэрээ, дүгнэлт


Хавсралт 1. Ус шүршигч төхөөрөмж, хөрс бэхжүүлэгч бодисын судалгаа

ТООСЖИЛТ ДАРАХ ТӨХӨӨРӨМЖ, БОДИСЫН СУДАЛГАА

Хөөтийн нүүрсний уурхайн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнд заагдсаны дагуу тоосжилт дарах төхөөрөмж, бодисын судалгааг хийж гүйцэтгэлээ.

ТООСЖИЛТ ДАРАХ ТӨХӨӨРӨМЖ:


№	Тоног төхөөрөмжийн нэршил	Ашиглах хэлбэрүүд	Хүчин чадал	Давуу тал	Үнийн судалгаа /тоног төхөөрөмжийн үнэ/	Зураг
1	Мананжуулагч буу /Fog cannon/	Өндөр цамхаг	Шүрших хүрээ 30-120м Насосны хүч 2.2-11 кВт Усны хэрэглээ 3-12 м ³ /д Манангийн ширхэгийн диаметр 0.02-0.2мм Ажлын температур 0-50 ^o	- Алсын удирдлага, ухаалаг самбартай - Дуу чимээ тусгаарлагчтай - Усны насос хөнгөн, зэвэрдэггүй ган	\$3000-5000	
2		Чиргүүл		- Алсын удирдлага, ухаалаг самбартай - Дуу чимээ тусгаарлагчтай - Агаар цэвэршүүлнэ. - Зөөвөрлөх боломжтой. - Усны насос хөнгөн, зэвэрдэггүй ган	\$10000	
3		Тэвэрийн хэрэгсэл		- Дуу чимээ тусгаарлагчтай - Энгийн ус цацагчтай харьцуулахад усны 40% хүртэл хэмнэж, тоосжилтийг 3-4 дахин бууруулна. - Агаар цэвэршүүлнэ.	\$61800	


4		Суурин		- Алсын удирдлага, ухаалаг самбартай - Дуу чимээ тусгаарлагчтай - Усны насос зэвэрдэггүй ган - Нарийн ширхэгт тоосыг дарах чадвартай - Эрчим хүчний хэрэглээ бага	\$3000-5000	
---	--	--------	--	---	-------------	---

Дүгнэлт: Тоос дарах зориулалттай мананжуулагч төхөөрөмжийг Монгол улсад хэрэглэж буй туршлага судалгаа байхгүй байгаа ба дээрх судалгааг БНХАУ-ын Shandong Huali Electromechanical компани, Бельги улсын Savic группын үйлдвэрлэсэн тоног төхөөрөмжийг үндэслэн хийлээ.

Дээрх тоног төхөөрөмжүүд нь усны хэрэглээг хэмнэх, агаарт дэгдэх нарийн ширхэгт тоосонцорыг бууруулах, агаарыг цэвэршүүлэх зэрэг байгаль орчинд ээлтэй давуу талуудтай ч уурхайн замын тоосжилтыг дарахад олон ширхэгээр хэрэглэх шаардлагатай тул ашиглахад тохиромжгүй, өндөр үнэтэй байна. Монгол улсад Экокойл ХХК нь Savic группын албан ёсны төлөөлөгчөөр ажилладаг байна.

ТООС ДАРАХ БОДИС:

№	Төрөл	Мэдээлэл	Давуу тал	Сул тал	Үнэ	Зураг
1	Гигроскопийн давс	Гигроскопийн давс нь орчны агаар дахь чийгийг өөртөө шингээснээр замын гадаргуу чийгтэж, тоосжилт буурна. Энэ бүлгийн хамгийн түгээмэл бодисууд нь натрийн хлорид, магнийн хлорид, кальцийн хлорид юм. Эдгээрээс кальцийн хлорид (CaCl ₂) нь тоосжилт дарах үзүүдэлтээрээ хамгийн өндөр байдаг.	Гигроскопийн давс нь түгээмэл байдаг бөгөөд үнийн хувьд хямд байдаг. Кальцийн хлоридыг тоосжилт дарахад ашигласнаар усны хэрэглээг 90% хүртэл бууруулах боломжтой ба давсны уусмалыг бэлдэхэд шаардагдах усны хэмжээ нь органик нэгдлүүдтэй харьцуулахад бага.	Энэ төрлийн давсны уусмал нь тэвэрийн хэрэгслийн ёмкостиг зэврүүлэх идэмхий шинж чанартай.	1 кг 30000- 50000 төг	

2	Органик нэгдэл:	Органик нэгдлүүдэд лигносульфонат, техникийн зориулалттай, биоадралтургамлын тос зэрэг орох ба тоосонцорыг барьцалцуулан, замын гадаргууг бэхжүүлэн тоосжилтыг бууруулна.	Эдгээр органик нэгдлүүдийг ашиглан барьцалдуулагч бэлтгэхэд бага хэмжээний ус шаардагдах бөгөөд тоосжилт дарах усны хэрэглээг 73% хүртэл бууруулаг. Ялангуяа хуурай уур амьсгалтай бүс нутагт илүү тохиромжтой.	Эдгээр нэгдлүүд нь замын тоосжилтыг дарахад үр дүнтэй боловч гулгамтай шинж чанартай болдог. Кальцийн хлорид ашигласнаас зардлын хувьд харьцангуй өндөр байдаг.	-	
---	-----------------	---	---	---	---	---

Дүгнэлт: Хөрс бэхжүүлж, тоосжилт дарах нэмэлтүүд нь дээрх 2 төрөлд хуваагдах ба тухайн нэмэлт бодисуудыг ашиглах судалгааны ажлууд хийгдэж байгаа ч практикт өргөн цар хүрээтэйгээр хэрэглэж эхлээгүй байна.

Монгол улсад 2022 онд натрийн лигносульфонат, кальцийн хлорид /CaCl₂/, ANT /органик нэгдэл/ хөрс бэхжүүлэгч бодисын туршилт хийгдэж туршилтын дүнгээр натрийн лигносульфонат, кальцийн хлорид нь тоосжилтыг /PM 10/ 45%-иар, ANT хөрс бэхжүүлэгч нь тоосжилтыг /PM 10/ 54%-иар бууруулсан байна.

Дээрх нэмэлтүүдийг уурхайн замын тоосжилт дарахад хэрэглэх боломжтой ч хэр хугацаанд тоосжилтыг дарах болон цаашид байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь тодорхойгүй байна.

Хөрс бэхжүүлэгч нэмэлтүүдийг Монгол улсад “Майнинг Технологи Энд Экуйпмент ХХК, Экосоил ХХК-иуд худалдан борлуулдаг байна.

Хавсралт 2. Өвс хүлээлгэн өгсөн акт



“ХӨӨТ”-ИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ

2023 оны 02 сарын 08 өдөр

№.

Дундговь аймаг
Баянжаргалан сум

ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН МАЛЧИН ӨРХҮҮДЭД
ӨВС ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН АЖЛЫН АКТ

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Хөөтийн нүүрсний уурхай нь нийгмийн хариуцлагын хүрээнд тус сумын 20 малчин өрхөд 2023 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр нийт 200 боодол өвс хүлээлгэн өгч хамтран ажиллав.

Энэхүү ажилд нийт 2,305,157 /хоёр сая гурван зуун таван мянга зуун тавин долоо/ тогрөгийг зарцуулав.

Өвс хүлээлгэн өгөх үеийн фото зургийг хавсаргав.

Хавсралт 1 хуудастай.

Хүлээлгэн өгсөн:

Уурхайн дарга

Байгаль орчны инженер

А. Эрдэнэбаатар

Б. Гэрэлтуяа

Хүлээн авсан:

Сумын засаг дарга

1-р багийн дарга

2-р багийн дарга

3-р багийн дарга

Т. Цэвэлмаа

Н.Мөнгөнхуяг

Э.Дашдамба

А.Отгонсүрэн

Дундговь аймаг, Баянжаргалан сум, 2-р баг, Энгэр усны бригад



Хавсралт №1. 200 боодол өвс хүлээлгэн өгч буй фото зургууд

Хавсралт 3. Уурхайн байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх зардлыг БОАЖЯ-ны тусгай дансанд байршуулсан баримт

ХААН БАНК Огноо/Date: 2023.08.04 09:44:59

Шилжүүлгийн мэдээлэл / Transaction information
Журналын / Journal No: 3315473

Системийн огноо / System Date: 2023.08.04

Дт	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5038 007 687	МОНГОЛЫН АЛТ МАК	10,019,500.00 MNT	1.00
/ арван сая арван есөн мянга таван зуун төгрөг /				
Кт	Банкны дугаар / Branch No	Банкны нэр / Bank Name	10,019,500.00 MNT	1.00
	90	- Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/Card Number	Нэр/Name		
	100900013406	БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА		

Гүйлгээний утга / Transaction description:
ЕВ-МАК Хөөт 2023 менеж.төлөвл. барьцаа 50%

Харилцагч танд баярлалаа. / Thank you to our customers

ХААН БАНК Огноо/Date: 2023.08.04 09:44:25

Шилжүүлгийн мэдээлэл / Transaction information
Журналын / Journal No: 3322866

Системийн огноо / System Date : 2023.08.04

Дт	Дансны/Картын дугаар Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5038 007 687	МОНГОЛЫН АЛТ МАК	8,300,500.00 MNT	1.00
/ найман сая гурван зуун мянга таван зуун төгрөг /				
Кт	Банкны дугаар / Branch No	Банкны нэр / Bank Name	8,300,500.00 MNT	1.00
	90	- Төрийн Сан		
	Дансны/Картын дугаар Account/Card Number	Нэр/Name		
	100900013406	БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА		

Гүйлгээний утга / Transaction description:
ЕВ-МАК Хөөт барьцаа 50% төлбөр

Харилцагч танд баярлалаа. / Thank you to our customers



“ХӨӨТ”-ИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ

2023 оны 10 сарын 10 өдөр

№. 04

Дундговь аймаг
Баянжаргалан сум

УУРХАЙН ШҮҮРЛИЙН УСНЫ НАСОСНЫ ТООЛУУРЫГ СОЛЬЖ СУУРИЛУУЛСАН АКТ

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Монголын Алт” (МАК) ХХК-ийн Хөөтийн нүүрсний уурхайн шүүрлийн усны насос гацаж, тоолуурын заалт буруу гүйж эхэлсэн тул LXLG-150 загварын 250м³ цагийн хэмжих хязгаартай, 150мм-ийн голчтой, №2303099631 дугаартай, 000014м³ заалттай, 018 лацаар битүүмжилсэн тоолуурыг 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Баянжаргалан сумын Байгаль орчны мэргэжилтэн Х.Сарангэрэл, уурхайн дарга А.Эрдэнэбаатар, байгаль орчны инженер Б.Гэрэлтуяа, уулын мастер П.Эрдэнэбат, насосчин Т.Отгонбаяр нарын бүрэлдэхүүнтэй сольж суурилуулсан болно.

Тоолуурын баталгаат хуудас болон тоолуур суурилуулах үеийн фото зургийг хавсаргав.

Акт үйлдсэн:

Баянжаргалан сумын байгаль
орчны мэргэжилтэн:

Х.Сарангэрэл

“Монголын Алт” (МАК) ХХК-ийн

Уурхайн дарга:

А. Эрдэнэбаатар

Байгаль орчны инженер:

Б. Гэрэлтуяа


Уулын мастер

П.Эрдэнэбат

Насосчин:

Т.Отгонбаяр

Дундговь аймаг, Баянжаргалан сум, 2-р баг, Энгэр усны бригад



Зураг 2. Тоолуурын заалт, лац



Зураг 3. Тоолуур солих үйл явц

Хавсралт 5. Дахивар хүлээлгэн өгсөн акт



“ХӨӨТ”-ИЙН НҮҮРСНИЙ УУРХАЙ

2023 оны 10 сарын 08 өдөр

№.

Дундговь аймаг
Баянжаргалан сум

Дундговь аймгийн дахивар авах цэгт хаягдал
хуванцар сав хүлээлгэн өгсөн акт

Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй
Хөөтийн нүүрсний уурхай нь ахуйн хэрэглээнээс гарсан ^{594 кг} хаягдал хуванцар сав, ^{47 кг}
цаасан хайрцгийг Мандалговь хотын “Баялаг төв” дахивар авах цэгт 2023 оны 10 дугаар
сарын 08-ны өдөр хүлээлгэн өгөв.

Хүлээлгэн өгсөн:

Байгаль орчны инженер

Б.Гэрэлтуяа

Хүлээн авсан:

Албан тушаал



Овог нэр

Дундговь аймаг, Баянжаргалан сум, 2-р баг, Энгэр усны бригад

НХМаягт БМ-3

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын
 5-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт

ЗАРЛАГЫН БАРИМТ № _____

Өндөр ХХК

Монголын Алт Хөөтийн нүүрсний уурхай

(байгууллагын нэр)

(худалдан авагчийн нэр)

Регистрийн №

Регистрийн №

20²³ оны 10 сарын 08 өдөр

(тээвэрлэгчийн хаяг, албан тушаал, нэр)





№	Материалын үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	Код	Хэм-жих нэгж	Худалдах		
				Тоо	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	<i>PET хувцас</i>		<i>м</i>	<i>65</i>		
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						
10						
11						
12						
13						
14						
15						
16						
17						
18						
19						
20						
	Дүн					

Тэмдэг

Хүлээлгэн өгсөн эд хариуцагч:
 Хүлээн авагч
 Шалгасан нягтлан бодогч



Хавсралт 6. Аюултай хог хаягдлын гэрээ, хүлээлгэн өгсөн аюултай хог хаягдлын дагалдах
маягт

<p>БАТЛАВ: “МОНГОЛЫН АЛТ” (МАК) ХХК -ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЦОЛМУУН</p>  	<p>БАТЛАВ: “ТҮМЭН ЭГШИГ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛТ ЧИНЗОРИГ</p>  	
<p>АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ</p>		
2021 оны 10 сарын 13-ний өдөр	№ 964-1121	Улаанбаатар хот
<p>Нэг талаас “Түмэн-Эгшиг” ХХК /цаашид “Хүлээн авагч” гэх/, түүнийг төлөөлж Ерөнхий менежер Б.Одбаяр,</p> <p>Нөгөө талаас “Монголын Алт” (МАК) ХХК /цаашид “Үүсгэгч” гэх/, түүнийг төлөөлж Хангамж, техник үйлчилгээний газрын Захирал Д.Нинжбадгар бид нар харилцан тохиролцож Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын 2018 оны 116-р тогтоолын 1, 2-р хавсралт болох “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаал болон Байгаль орчны аюулгүй байдалтай холбогдох хууль, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.</p>		
<p>НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА</p>		
<p>1.1. Энэхүү гэрээгээр Аюултай хог хаягдал үүсгэгчээс аюултай хог хаягдлын дагалдах бичгийн дагуу түүнээс гарч байгаа аюултай хог хаягдлыг хүлээн авагч нь хүлээн авч түр хадгалах, дахин боловсруулах, устгалд оруулах, үүсгэгч нь хүлээн авагчид тохиролцсон үнийг төлөх болон талуудын эдлэх эрх, үүрэг хариуцлагын талаар зохицуулна.</p> <p>1.2. Энэ гэрээгээр шууд зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын Хог хаягдлын тухай хууль, Иргэний хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулна.</p> <p>1.3. Үүсгэгч гэдэгт “Монголын Алт” (МАК) ХХК болон дор дурдсан түүний охин болон хамаарал бүхий компанийг хамтад нь ойлгоно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">1.3.1. “МАК Цемент” ХХК;1.3.2. “Хүрэн толгой коал майнинг” ХХК;1.3.3. “Эрдэнэс цагаан суварга” ХХК;1.3.4. “Тру ти ар си” ХХК. <p>1.4. Аюултай хог хаягдлын тоо хэмжээ, төрөл болон үнийн талаар гэрээний Хавсралт 1-т тусгах ба талууд гэрээний хугацаанд аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртгээ дагалдах бичгийг гэрээнд хавсаргах ба энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.</p>		
<p>ХОЁР. АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА</p>		
<p>2.1. Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэглэгээ хийсэн байна.</p> <p>2.2. Аюултай хог хаягдал савласан сав бүр нь ямар химийн бодис хадгалж байсан тухай нэр шошготой байна.</p> <p>2.3. Үүсгэгч нь аюултай хог хаягдлыг шилжүүлэх бүртгээ үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаарх бүртгэлийг хүлээн авагчид шилжүүлнэ.</p> <p>2.4. Аюултай хог хаягдлыг шилжүүлэхдээ <u>БОАЖЯ Сайдын 2018 оны 02-р сарын 02-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг</u> бүрдүүлж өгнө.</p> <p>2.5. Аюултай хог хаягдлын <u>савыг суллаж онц хортой, тэсрэмтгий, шатамхай бодис /тухайлбал цианид натри гэх мэт/ -г тухайн бодисын шинж чанарт тохирсон уусмалаар цэвэрлэсэн байна.</u> Хоосон сав нь ЗГ-н 2018 оны 116-р тогтоолын 1-р хавсралтын 5.7-5.9-д заасан шаардлагыг хангасан байвал зохино.</p>		
<p>2</p>		

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

№ *01/0208*

Дагалдах бичгийн дугаар:

/ шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ. /

1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:								
Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: <i>МАК ХХК Хөөтийн Уурхайн</i>								
Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: <i>МАК ХХК Хөөтийн Уурхайн</i>								
2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:								
Овог нэр	Албан тушаалтан	Гарын үсэг:	Огноо:					
			2023 он <i>10</i> сар <i>17</i> өдөр					
3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:								
1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар <i>18.1446M</i> Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар <i>000022</i>								
4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:								
	Аюултай хог хаягдлын нэр	Аюулын ангилалын зэрэглэл	Савлагааны бүлэг	Савны		Хэмжээ	Нэгж /кг Эсвэл/ ш	Аюултай хог хаягдлын код
				дугаар	Төрөл			
1	<i>Бонд</i>	<i>Х</i>				<i>2000</i>	<i>кг</i>	<i>105160</i>
2								
3								
4								
3. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт заарчиглал, мэдээлэл: <i>Төрийн Зориулалтын зориулалт хэрэглэ</i>								
5. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч: <i>Төрийн Зориулалтын ХХК</i>								
1. Овог нэр:	<i>В. Сүдбаяр</i>	Гарын үсэг:	<i>В. Сүдбаяр</i>	Огноо:	2023 он <i>10</i> сар <i>17</i> өдөр			
6. Үл зохицол: <i>гүйц.</i>								
8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:								
Аж ахуйн нэгжийн нэр: ТҮМЭН ЭГШИГ ХХК								
Түмэн эгшиг ХХК бүртгэлийн дугаар: -000022								
Аюултай хог хаягдлыг хүлээн авсан:								
